

Увс аймгийн Өмнөговь сум

**“ТӨРӨЛХ НУТГАА
ХӨГЖҮҮЛЬЕ”**

**2020 ОНЫ ӨМНӨГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД 5-Р БАГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИХ
ЦЭНД ОВОГТОЙ ГАНТӨМӨРИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 он

Уриа: “Төрөлх нутгаа хөгжүүлэе”

Нэг. Нийгмийн бодлогын хүрээнд

1. “Ахмад, дунд, залуу” гурван үеийн алтан хэлхээг хангаж, ахмадаасаа суралцаж, дунд үеийнхэн хүчтэй хөдөлмөрлөж, залуу үеэ халамжлан хүмүүжүүлэх замаар сумаа хөгжүүлэх үйлсэд иргэдийнхээ оролцоог тэгш хангах бодлого баримтлана.
2. “Сумандаа сайхан амьдаръя” төсөл санаачилж, иргэдийнхээ ая тухтай, эмх цэгцтэй ажиллаж амьдрах нөхцөлийг хангах бодлого хэрэгжүүлж ажиллана.
3. Хүүхдийн “Хөдөлмөр” амралтын зусланг сэргээн хөгжүүлж, амьдрах ухаан, мал аж ахуй эрхлэх монгол ахуйд суралцуулна.
4. Ахмад, эмэгтэйчүүд, залуучууд, хүүхдүүд болон төрийн албан хаагчдын уулзалтыг үе шаттай зохион байгуулж, тэднээс гаргасан зөв зүйтэй санал, санаачилгыг дэмжиж сумын хөгжлийн бодлого, зорилтод тусгаж хэрэгжүүлж ажиллана.
5. Сумын Хурал, Засаг даргын тамгын газар болон төрийн үйлчилгээний байгууллагуудын ажлын уялдаа холбоо, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч төрийн албанд мэдлэг, чадвартай боловсон хүчнийг сонгож, томилдог болох зарчмыг хэрэгжүүлж, төрийн байгууллага, албан тушаалтанд хяналт тавьж ажиллана.
6. Сумын иргэд, ялангуяа малчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах ажлыг тухай бүр хийж байх бодлого хэрэгжүүлнэ.

Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд

1. Хууль, журмыг зөрчиж ах дүү, танил тал, нам, баг болон тойрон хүрээлэгчдээ дэмжиж төсөл, тендер өгдөг явдлыг таслан зогсоож, хийж бүтээе, ажлын байр нэмэгдүүлье гэсэн иргэн, ААН-д төсөл, тендерийг олгодог болох бодлого барьж, үр ашигтай жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
2. Дотоодын аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа энэ үед сумын аялал жуулчлалын маршрут гарган түүх, соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудаа жуулчдад үзүүлж сонирхуулах замаар малчид, аж ахуйн нэгж, иргэд орлого олох боломжийг бүрдүүлнэ.
3. Малын гаралтай түүхий эд /арьс, шир, ноос ноолуур/-эд суманд анхан шатны боловсруулалт хийж, түүхийн эдийн үнэ ханшийг нэмэгдүүлэхээр зорьж байгаа иргэн, ААН-ийн үүсгэл, санаачилгыг бодлогоор дэмжинэ.

Гурав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

1. Малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, вакцин, эм тариаг цаг хугацаанд нь чанар, хүртээмжтэй хийлгэх, мал угаалгын ванныг илүү боловсронгуй болгоход анхаарч, мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн ажлын тайланг малчдад тавиулж хэвшинэ.
2. Мал цөөтэй өрх болон мал маллах сонирхолтой залуу малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор “Үр дүнтэй малжуулалт” төслийг төр, хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлэхийг зорино.
3. “Хар хаг”-ийн услалтын системийг сэргээж, усалгаатай газар тариаланг хөгжүүлэн, малын тэжээлийн үйлдвэр, цехтэй болох ажлыг эхлүүлж, зарим багуудыг хадлангийн талбайтай болгох тал дээр анхаарна.
4. Аймгийн аварга малчинд тодорхойлох, сумын аварга малчин шалгаруулж шагнадаг журмыг илүү боловсронгуй болгоход анхаарч, тухайн багийн ИНХ-аар хэлэлцэгдэж, олонхийн дэмжлэг хүлээсэн хүнийг аймаг, сумын аваргаар шалгаруулж, хөдөлмөр зүтгэлийг зөв бодитоор үнэлэх тогтолцоог бий болгоно.